



**НИЙСЛЭЛИЙН
СПОРТЫН ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 05 сарын 28 өдөр

Дугаар A/35

Улаанбаатар хот

Хийн дасгал болон аэробикийн
сургагч багш бэлтгэх сургалт
семинар зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Хийн дасгал болон аэробикийн сургагч багш бэлтгэх сургалт семинарыг 2019 оны 06 дугаар сарын 10-19-ний өдрүүдэд Хан-Уул дүүргийн Биеийн тамир, спортын хорооны спорт зааланд зохион байгуулсугай.
2. Сургалт семинарыг зохион байгуулахад шаардагдах төсвийг нэгдүгээр, хичээл заах багш нарын бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Сургалт семинарт шаардагдах 2.900.000 /Хоёр сая есөн зуун мянган/ төгрөгийг Нийслэлийн спортын хорооны биеийн тамирын уралдаан тэмцээний зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /Л.Төгөлдөр/-д зөвшөөрсүгэй.
4. Сургалт семинарын урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж, зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг Нийтийн биеийн тамирын хөгжлийн хэлтсийн дарга /А.Болдмаа/-д үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ж.ГАНБОЛД

Нийслэлийн спортын хорооны даргын 2019 оны
М.В. Дугаар сарын *28*-ны өдрийн *А/В* дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

Хийн дасгал болон аэробийкийн сургагч
багш бэлтгэх сургалт семинар зохион
байгуулах төсөв

№	Зардлын нэр	Нийт дүн /төг/
1.	Багшийн ажлын зардал: 10 хоног х 60 цаг х 30.000 төг = 1.800.000 төг	1.800.000
2.	Заал талбайн зардал:	400.000
3.	Сертификат хэвлүүлэх	100.000
4.	Гарын авлага, сурталчилгаа	600.000
ДҮН:		2.900.000

Нийслэлийн спортын хорооны даргын 2019 оны
дугаар сарын 18-ны өдрийн дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт



Хийн дасгал болон аэробийн сургагч багш бэлтгэх
сургалт семинарын хичээл заах
багш нарын бүрэлдэхүүн

- | | |
|-----------------|--|
| 1. Ц.Март | Монголын гимнастикийн холбооны зөвлөх багш |
| 2. Х.Оюунчимэг | Монголын бие тэтгэх хийн дасгалын холбооны тэргүүн |
| 3. А.Болорцэцэг | Монголын гимнастикийн холбооны зөвлөх багш |
| 4. А.Болдмаа | НСХ-ны НБТХөгжлийн хэлтсийн дарга |
| 5. Ц.Энхтуяа | Монголын гимнастикийн холбооны шүүгч |
| 6. Н.Ариунаа | Монголын гимнастикийн холбооны шүүгч |